



ДУНДГОВЬ АЙМАГ  
ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 10 өдөр

Дугаар А1104

Сангийндалай

Модны талбай руу 380 вольтын цахилгаан  
татах зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.8 дахь заалт, "Ойн тухай хууль"-ийн 18 дугаар зүйлийн 18.2.1 дэх заалт, "Төсвийн тухай хууль"-ийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг зарцуулах, тайлагнах журмын 3 дугаар зүйлийн 3.5.3, 3.6.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Их ус баянбүрд 1,2 талбайд 380 вольтын цахилгаан татах ажлыг "АНАР ЗОНЕ ХХК"-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлсүгэй.

2. Уг ажилд шаардагдах 7,500,000 (долоон сая таван зуун мянган) төгрөгийг Байгаль орчныг хамгаалах сангаас зарцуулахыг нягтлан бодогч (Т.Энхбат)-д зөвшөөрсүгэй.

3. Дээрх ажилд хяналт тавин ажиллахыг Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн (Д.Батбаяр), 7-р багийн Засаг дарга (Ж.Түвшинбаатар) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ЛХАГВАМАНДАЛ



482302297